

“Маш гайхамшигт баясгалангийн хуримын сан” зохиолын агуулгад хийсэн шинжилгээ

Хасхуягт Д.¹, Улаан-Од Х.², Шагдарсүрэн Д.³, Болд Ш.¹

¹Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Монгол анагаах ухааны олон улсын сургууль

²“Ач” Анагаах ухааны их сургууль, ³Долмалин эмнэлэг

Abstract

Analysis of Contents of the “Ngo mtshar dga’ ston gter mdzod”

Khaskhuyag D.¹, Ulaan-Od Kh.², Shagdarsuren D.³, Bold Sh.¹

¹International School of Mongolian Medicine,
Mongolian National University of Medical Sciences

²“Ach” Medical University and ³Dolmalin Hospital

Chojamts, the Buddhist image-maker and dge long of the Niislel Khuree (Capital Camp), lived during the last period of the 19th and early 20th centuries. He wrote a book “Gso rig gzhung mang bsdus pa’i bdud rtsi’i snying po tsha grang zug ngu sel ba’i ngo mtshar dga’ ston gter mdzod zhes bya ba bzhugs so” in short ngo mtshar dga’ ston gter mdzod. This is the comprehensive book about Traditional Mongolian medicine in Tibetan language and written by Mongolian scholar.

In the chapter 126, Chojamts mentioned a special treatment he calls “Mongol cure.” In this chapter, patients have a bath with boiled, hot, and warm essences with ingredients of distilled whey, mare’s milk, vodka, tea, salt, salt-marsh, and Artemisia absinthium. Artemisia was used in order to cure kidneys, bad blood, and bile, hands, and legs to become numb, rheumatism, and bam-scurvy. Also it was mentioned that it is very good to cure tsagaan huyan (chronic of nerves) diseases and other radiculopathy. Careful preparations of that cure are vital before the Mongol cure-whey treatment begins.

Chojamts classified 30 commonly occurring diseases out of 64 wind diseases plus 47 bile’s diseases into warm and cold diseases. Also he divided phlegm into own root and other’s root. Then he classified further 6 common diseases out of 41 own root diseases and other’s root diseases as ulcer (bor uvchin) and chronic phlegm (badgan) disease in respiratory organ. Also he taught that ulcer is warm disease and phlegm is cold disease. In addition, he healed 30 wind diseases with 3 different medicines.

In addition, he mentioned that what kind of prescription is more effective to the diseases based on his own experience. Specifically, he describes how to choose the most popular prescription and how to prescribe the prescriptions in terms of weather and body temperament.

Key words: Chojamts, diseases, cure, hot, and warm

Pp. 113-116 , References 8

Үндэслэл

1990 оноос уламжлалт анагаах ухаан сэргээгдэн хөгжөөд 30 шахам жил өнгөрч, уламжлалт анагаах ухаан судлалын хүрээнд олон арван сурах бичиг, бүтээл гарч, мэргэжилтэй боловсон хүн бэлтгэгдэж байгаа хэдий ч уламжлалт эмнэлгийн тусламжийн чанар, эмч нарын мэдлэг, мэргэжлийг эрс дээшлүүлэх шаардлагатай байна. Ингэхийн тулд уламжлалт анагаах ухааны оюутнуудад өгч байгаа мэдлэгийг “нотолгоонд тулгуурласан”, уламжлал, шинэчлэлийг оновчтой хослуулсан “ухаан” болгох нь чухал юм [1].

Нэн ялангуяа XXI зууны уламжлалт анагаах ухааны хөгжлийн үндэс нь өмнөх үеийн эмч, эрдэмтдийн бүтээн туурвисан анагаах ухааны хуучин ном, судрыг уншиж судлах, уг номонд байгаа шинжлэх ухааны үндэстэй ойлголтыг гүнзгийрүүлэн ухаарах, эмч, маарамба нарын гарын авлага, увдисыг гүн утгыг онож ойлгох, тайлбар, тайлал хийх асуудал тулгам болоод байна. Үүнийг шийдвэрлэхэд чухал түлхэж өгөх судалгааны чиглэл нь уламжлалт анагаах ухааны сурвалж бичгийн судлалын ажлыг гүнзгийрүүлэх, өргөжүүлэх явдал юм.

хан, Данзанпунцаг, Арьяа бандида, Чойнпил тойн, Ишданзанванжил, Мижиддорж зэрэг нэр Энэтхэгийн Аюурвед, Монгол, Төвөдийн анагаах ухааны мэргэдийн зохиосон олон арван судраас хураан номлосон, эмийн гол судруудаас чухал зүйлүүдийг түүж бичсэн, Ар Монголын эмийн баримжаа болсон бүтээл учир сүүлийн үеийн эмч, судлаач нарын ширээний чухал ном болох юм [3]. Үүгээр үл барам уг номонд тэр үеийн орос, хятад эмнэлгийн эмийг хэрхэн хэрэглэх талаар дурдсан нь зохиогчийн мэдлэг, судалгааны арга зүй их өндөр байсныг гэрчилнэ.

"Маш гайхамшигт баясгалангийн хуримын сан" нийт 129 бүлэгтэй бичлэгийн хэлбэр, бүлгийн дараалал нь төвөд эмнэлгийн зохиолуудаас зарчмын ялгаатай харин Сүмбэ хамба зэрэг монгол эрдэмтдийн бичлэг, дараалалтай адилавар [4] байгаа нь тайлбар бус шинээр бичсэн зохиол гэж үзэхээр байна. "Анагаах ухааны дөрвөн үндэс", түүний тайлбар зохиолууд эхлээд үндсэн 3 бүлгийнхээ товч утга "Язгуурын үндэс"-ыг дараа нь "Онолын үндэс", "Эмчилгээний үндэс" хамгийн сүүлд судал, шээсийг багтаасан "Хойд үндэс" гэсэн тогтсон дараалалтай байдаг [5].

Чойжамц эхлээд оношлогооны үндсэн арга судас, шээсээр шинжлэх аргыг товч, тодорхой дурдаад, Зөн билгийг бүтээх увдис, Өвчтөний эдгэх, үхэхийг тооцох арга зэрэг хүссэн хэрэг бүлэгтээ өөрийн болон бусдын гэм, эрдмийг тодруулан, хоосон чанарыг гүн бясалган эдгэх, үхэх шалтгаан, нөхцлийг эндүүрэлгүй мэдэх зөн билгийн бүтээл, эдгэх, үхэх шинжийг тоолох арга, найман хүлэлийн 4 гүйдэл, мэнгэ голлох түүний тайлбарыг багтаажээ [6].

Тавдугаар бүлэгтээ эмийн чадал, эрдэм, залгаад эрдэнийн эм номхотгох арга, шүтэн барилдах учралыг бичсэн байна. Наймдугаар бүлгээс авахуулаад 125 дугаар бүлэг хүртэл зонхилон тохиолддог өвчний эмчилгээг бичжээ.

Өвчнийг гэм, эрхим, орон, язгуураар бус амьдралд тохиолддог, бодитой оршдог үндсэн өвчнүүдээр ялгасан нь үнэхээр сонирхолтой бөгөөд үүгээрээ аргагүй л монгол хөрсөн дээр буусан бүтээл юм. Тухайлбал хийн 64 өвчнөөс Монголд оронд тохиолддог 30 өвчнийг, шарын 47 өвчийг ердөө л халуун, хүйтэн 2-т хуваагаад, бадганыг өөрийн үндэст, бусдын үндэст гэж 2 хуваагаад өөрийн үндэст 41 өвчнөөс язгуур болсон 6, бусдын үндэст өвчнийг бор, цайвар үүнээс бор нь халуун, цайвар нь хүйтэн өвчин

хэмээн мэдэхийг заажээ [7]. Энэ нь өнөөгийн уламжлалт эмнэлгийн өвчний ангиллыг зохиоход суурь болж өгөх нь дамжиггүй юм.

125-аас 127 дүгээр бүлгийн хооронд 93 өвчнийг дарах эмийн жор, заслрудыг багтаасан байна. Жоруудын дотор бидний практикт төдийлөн хэрэглэгддэггүй тан, талх эмүүд болон нэрмэлийн шар ус, айраг, архи, цай, хужир, давс, агь нугуудыг чанаад, бүлээн болсны тус эрдэм нь бөөрний өвчин, муу цус, шар ус, судас дагаж тархсан хийгээд хөл гар шархирч явж суухад өвдөх, тулай хэрх, бам чийг, хуян, шар ус, сүүжний нүхээр хатгах тэргүүтний өвчнийг засахын дээд" [8] гэх мэтээр бичжээ.

Дүгнэлт

Бурхан урлаач, гэлэн Чойжамцын бичсэн Маш гайхамшигт баясгалангийн хуримын сан" зохиол нь өвчин тус бүрийг амар хялбар оношлон таних, шинж тэмдгүүдийг маш оновчтой тодорхойлон гаргаж, эмийн жор найралтын зүйлийг нэг бүрчлэн хийж үзсэн амтшил туршлагаар шинжилж батлаад, эмчилгээнд хэрэглүүлэхээр зааж бичсэн нь бусад эмийн жор найралтын судраас ихээхэн ялгарах онцлогтой болсон байна.

Түүнчлэн ямар өвчнийг ямар эмээр засахад илүү үр дүнтэйг эмчилгээний олон хувилбарт жороос сонгон олж, эмийн жор найралтыг орон, цаг, бие махбод лугаа зохилдуулж, эмээр засах, ариутган адистидлэх, бясалгах, зайн тарнийн нууц чадлыг хавсруулж, Энэтхэгийн сонгодог онол, Төвөдийн эмчилгээний уламжлал, Монголын эм эмнэлгийн язгуур хар аргыг хүртэл хэрхэн хослуулан хэрэглэхийг туршлагат тулгуурлан бичиж үлдээжээ. Жишээлбэл: Нүдний эрхтэн-18 эм нь нүдний өвчин алинд ч өөрөө гарсан рашаан мэт хэрэгтэйг би өөрөө үзлээ гэх буюу Харанхуйг арилгагч нарны хот мандал хэмээх эмийн нүдний өвчнийг арилгах чадал туршлагаар батлагдсан гэх мэтээр бичжээ.

Мөн Амгаланг үүсгэгч шар хэмээх найрлага нь нийт бадган өвчнийг хяруунд нар тусах мэт дарна хэмээсэн нь эмийн чадлыг дурайтал товойлгоод зогсохгүй эмийн тусыг хэл найруулгын хувьд ч сонсголонтой сайхнаар өгүүлсэн гэж үзэхээр байна.

Ном зүй

1. Монголын уламжлалт анагаах ухааны эм судлал. Ерөнхий редактор, академич Ш.Болд. УБ, 2014, х.7

2. Чойжамц. *གསོ་རིག་གཞུང་མང་བསྐྱེས་པའི་བདུན་
ཆེད་ལྷོང་པོ་ཆ་གང་ཟུག་རྩ་སེལ་བའི་ངོ་* *མཚར་དགའ་སྟོན་གཏེར་
མཛོད་ཞེས་བྱ་བ་བཞུགས་སོ།* Анагаах ухааны олон гол
сурвалжаас хураасан рашааны шим, халуун,
хүйтний энэлгээг арилгагч маш гайхамшигт
баясгалангийн хуримын сан хэмээх оршивай.
Модон барын төвөд судар. Нийслэл Хүрээ,
1922.

3. Болд Ш, Жавхлан Б. Хүннүгээс XXI зууны
Монгол Улс хүртэлх үеийн эмч, маарамба, гүүш,
бариац нарын цадиг, бүтээлийн ойллого. УБ,
2016

4. Сүмбэ хамба Ишбалжир. Дөрвөн рашаан. Хөх
хот, ӨМАХХ, 1998

5. *བདུན་ཆེ་ལྷོང་པོ་ཡན་ལག་བརྒྱད་པ་གསང་བ་མན་ངག་གི་རྒྱུད་ཅེས་བྱ་བ་བཞུགས་སོ།*
Модон барын төвөд судар

6. Чойжамц. *གསོ་རིག་གཞུང་མང་བསྐྱེས་པའི་བདུན་ཆེད་ལྷོང་པོ་ཆ་གང་
ཟུག་རྩ་སེལ་བའི་ངོ་* *མཚར་དགའ་སྟོན་གཏེར་མཛོད་ཞེས་བྱ་བ་བཞུགས་སོ།*
Анагаах ухааны олон гол сурвалжаас хураасан
рашааны шим, халуун, хүйтний энэлгээг

арилгагч маш гайхамшигт баясгалангийн
хуримын сан хэмээх оршивай. Модон барын
төвөд судар. Нийслэл Хүрээ, 1922.

7. Чойжамц. *གསོ་རིག་གཞུང་མང་བསྐྱེས་པའི་བདུན་ཆེད་ལྷོང་པོ་ཆ་གང་
ཟུག་རྩ་སེལ་བའི་ངོ་* *མཚར་དགའ་སྟོན་གཏེར་མཛོད་ཞེས་བྱ་བ་བཞུགས་སོ།*
Анагаах ухааны олон гол сурвалжаас хураасан
рашааны шим, халуун, хүйтний энэлгээг
арилгагч маш гайхамшигт баясгалангийн
хуримын сан хэмээх оршивай. Модон барын
төвөд судар. Нийслэл Хүрээ, 1922.

8. Чойжамц. *གསོ་རིག་གཞུང་མང་བསྐྱེས་པའི་བདུན་ཆེད་ལྷོང་པོ་ཆ་གང་
ཟུག་རྩ་སེལ་བའི་ངོ་* *མཚར་དགའ་སྟོན་གཏེར་མཛོད་ཞེས་བྱ་བ་བཞུགས་སོ།*
Анагаах ухааны олон гол сурвалжаас хураасан
рашааны шим, халуун, хүйтний энэлгээг
арилгагч маш гайхамшигт баясгалангийн
хуримын сан хэмээх оршивай. Модон барын
төвөд судар. Нийслэл Хүрээ, 1922.

Танилцаж, нийтлэх санал өгсөн:

*Анагаах ухааны доктор, профессор
Д.Цэрэндагва*